



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/БЧБ

Мандалговь

Аймаг, сумдын баяр наадмыг
зохион байгуулахгүй байх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, дахь заалт, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2021 оны "Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх тухай" 171 дүгээр тогтоолын 3, 4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (ковид-19)-ын эрсдэлийн түвшин орон нутагт өндөр байгаа тул Ардын хувьсгалын 100 жил, аймаг байгуулагдсаны 79 жилийн ойн Үндэсний их баяр наадмыг аймаг, сумын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. Аймаг сумдын баяр наадамд зориулан төлөвлөсөн зардлыг Коронавируст халдвар (ковид-19)-ын хариу арга хэмжээний зардалд зарцуулах төслийг боловсруулан шийдвэрлүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Уул, овооны тахилга, наадам, тэмдэглэлт ой, хурдан морины уралдаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг аймгийн Уяачдын холбоо, Үндэсний бөхийн холбоо, Үндэсний сурын холбоо, болон сумдын Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

4. Хүн бүр хариуцлагатай байж, халдвар хамгааллын дэглэмээ баримтлан эрүүл мэндээ хамгаалж, эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандахыг нийт ард иргэдэд уриалсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ